

## ЛИБЕРАЛ ҮЗЭЛ САНАА БА ОРЧИН ҮЕ

Н.Ариунаа

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант

Ц.Өлзийжаргал

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант

Францын хөрөнгөтний хувьсгал Европ дахины капитализмын хөгжилд маш том нөлөө үзүүлсэн бөгөөд энэ хувьсгалын үрээр хамжлагат ёс, хаант засгийг эсэргүүцсэн олон нийтийн тэмцэл хүчтэй өргөжин бүгд найрамдах засгийн байр суурь бэхжэксэн юм. Ийм нөхцөлд төрийн үйл ажиллагааны бодлого, шийдвэрт нөлөөлөх сүм хийд, шашны догматик сэтгэлгээ үеэ өнгөрөөж Европын соёл иргэншилд дэвшилтэт улс төр, эрх зүйн үзэл санаанууд нэвтрэн хэрэгжиж эхлэх болсон. Англи, Франц, Герман, Швейцари зэрэг орнуудад өرنөн дэлгэрсэн хөрөнгөтний харилцаа тогтворжиж, хуучны аристократ феодалын ёс дэглэм нийгмээс шахагдаж байсан хэдий ч хүч нь сулраагүй эсэргүүцэл үзүүлсээр байсан юм. Тухайн үед баруун европд улс төр, эрхийн үзэл санаанд хүч түрэн орж ирсэн улс төрийн урсгал бол либерализм мөн. Либерализмын үзэл номполын цөм нь дараах хоёр сэдэв байдаг.

Үүнд: Нэгд, хувийн эрх чөлөө, хувь хүн бүрийн болон хувийн өмчийн эрх чөлөө бол социаль эрхэм дээд үнэт зүйлс мөн. Хоёрт, дээрх үнэт зүйлсийг хэрэгжүүлэх нь хувь хүний сайн сайхан байдалд тэмүүлэх бүтээлч эрч хүчийг нэмээд зогсохгүй, нийгмийг бүхэлд нь төдийгүй, түүний төрийн байгууллагуудыг хөгжил цэцэглэлд хүргэнэ гэж үздэг. Энэхүү цөм нь болсон дээрх сэдвийн зэрэгцээгээр хүн бүр өөрөө өөрийнхөө төлөө эзэн байх, нийгмийг рациональчаар өөрчлөн байгуулах, нийгмийн баялгыг арвижуулах, чөлөөт өрсөлдөөн, ажил хэрэгт хянамгай байх, засаглалыг хувиарлах, эрх зүйт төр, өөрийгөө удирдах ёсыг хөгжүүлэх, төлөөллийн удирдлага, үндсэн хуулийн зарчмыг баримтлах тухай зэрэг либерализмын үзэл санааны олон дэвшилт зарчмууд гарч ирсэн болно. Либерализмын үзэл санаа баруун Европд дэлгэрсэн нь өмнөх үе үеийн сэтгэгчдийн үзэл номлолтой салшгүй холбоотой. Тухайн цаг үедээ Аристотель хүн айх аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг төр нийгэм хангаж байх болон өмч баялаг хүнд байх ёстойг сургаж байсан. Хүн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг хүний жам ёсны эрх, эрх чөлөөний тухай Гоббс бичиж байв.

Энэхүү бяцхан өгүүлэлд либерал үзэл санааны эцэг гэгддэг XIX зууны хоёр том сэтгэгчийн тухайн үедээ дэвшүүлж байсан суут санаа оноо эдүгээ үеийн Монголын нийгмийн болон төрийн байгуулалтын шинэчлэлийн зорилтод нөлөө бүхий үр дагавар үзүүлэх нь тодорхой юм.

Английн их сэтгэгч Иереми Бентам /1748-1832/. И.Бентам өөрийн улс төр, эрх зүйн үзэл санаагаа дараах бүтээлүүддээ тусгасан байдаг. “Бүх төр улсууд дахь үндсэн хуулийн кодексийн эрхэмлэх зүйл”, “Засгийн газрын тухай өгүүлэх нь”, “Хууль тогтоох ёсны зарчмууд”, “Ёс суртахууны тухай шинжлэх ухаан”.

И.Бентамын либерал үзэл санаа дараах дөрвөн зүйлийг чухалчлан үзсэн байдаг.

1. Хүний амьдрал үйл ажиллагааны утга учир нь зовлон зүдгүүрийг угүйсгэж аль болох сэтгэл ханамжтай байдлыг олж авах.
2. Үр өгөөжтэй боломжит чанар аливаа нэгэн зорилтыг шийдэх хэрэгсэл тэр нь бүх үзэгдлийн үнэлэмжийн хамгийн ач холбогдолтой шалгуур.
3. Хамгийн олон тооны хүмүүст хамгийн илүү их аз жаргалыг хүртээх нь зан суртахуунт чанарын илрэл.
4. Бүх нийтийн ашиг тусын тулд хувийн болон нийгмийн ашиг сонирхлын зохиц харьцааг тогтоох нь хүн төрөлхтөний хөгжлийн зорилго.

Энэ бүхэн эрх чөлөө хангагдсан нөхцөлд л биелэх боломжтой гэж тэрээр үзжээ. 1789 оны 8 дугаар сарын 26-нд Францын иргэний эрх, эрх чөлөөний тунхаглал гарсан. Энэ нь аугаа их эрх чөлөөний тухай сайн сайхныг билэгдсэн тунхаглал мөн гэж Бентам үзээд харамсалтай нь энэ тунхаглалын үзэл санаа амьдралд хэрэгжихгүй байгааг зэмлэн шүүмжилж байв. Эрх чөлөө гэдэг ойлголт бол харьцангуй ойлголт. Эрх чөлөө нь хууль, дэг журам яаж мөрдөгдөж байгаагаас шалтгаална. Бентамын үзэж байгаагаар хууль ёс, дэг журам зөрчигдөх явдал бол хүмүүсийн буруу биш. Тогтолцооны гажуудалтай холбоотой. Тийм учраас засгийн газрын ажилтнууд ажил үүргээ ёс суртахуунтай гүйцэтгэх хэрэгтэй. Сонгуулийн үр дүнгээр байгуулагддаг бүгд найрамдах засгийг дэмждэг байв. Хууль тогтоох, гүйцэтгэх засаг, шүүх засаглалын тогтолцоо нь улс, нийгмийн асуудлыг шийдэхэд зөвшилцөлд хүргэдэг сайн талтай.

И.Бентам Английн парламент нэг танхимтай байх ба лордын танхимиийг татан буулгах ёстой гэж үзэж байв. Тэрээр улс төрийн системийг бүхэлд нь ардчилах тухай бичиж байсан бөгөөд сонгуулийн эрхийг өргөтгөх, эмэгтэйчүүдийг сонгуульд оролцуулах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах, олон нийтийн санаа бодлыг сонсох, мэтгэлцээн, нээлттэй хурал зохион байгуулах ажлыг ардчилалын институцуудийн тусламжтайгаар гүйцэтгэж хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьж болох юм гэсэн санааг тухайн үедээ тавьж байжээ. Төрийн гол үүрэг бол түүнийхээр иргэдийнхээ аюулгүй байдлын хангаж, эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалах явдал гэж үзэж байлаа. Төр иргэдийн хувийн амьдрал, эдийн засгийн хүрээний асуудалд орж хутгалдахыг тайшаадгүй байв. Бентамын гавьяа бол хууль ёсыг хуучныг баримталлагчдаас чөлөөлж, эрх баригчдад үйлчилдэг хэрэгслээс аль болох ангижуулж шүүх журам иргэд, ядуучуудад үйлчилдэг ардчилсан шинжтэй болгохыг эрмэлзэж байсанд оршино. Тиймээс нийгмийн системийн нийтлэг зорилго бол аль болох олон тооны хүмүүст илүү их аз жаргалыг хүртээх явдал хэмээн тэрээр үзэж байжээ.

Джон Стюарт Милль /1806-1873/ “Эрх чөлөөний тухай”, “Төлөөллийн удирдлага”, “Улс төр эдийн засгийн ухааны үндэс”- 5 дугаар бүлэг, “Засгийн

газрын нөлөөний тухай” зэрэг бүтээлүүд туурвисан. Бентамын үзэл санааг залгамжлагчдын нэг. Төр бол нийтийн сайн сайхан, хүний эрх, эрх чөлөөт байдлыг аян зөнгөөр нь хангаж чадахгүй. Харин төр иргэн бүрийн эрх, эрх чөлөө амьдрал, үйлдэл дээр ямар байна гэдгийг харгалзан үзэх ёстай. Төр бол иргэний ардчилсан төр байх ёстай. Иргэн бүрийн аз жаргал сайн сайхан амьдралаар төр баяжин бэхжинэ. Иргэн төр, нийгмийнхээ үйл хэрэгт сайн үйл гүйцэтгэгч, үйлчлэгч байх ёстай. Милль иргэн, төр хоёрын харилцаанд эрс шинэчлэл хийх оролдлого тавьсан. “Хүн өөрөө өөртөө эзэн байх ёстай”. Ингэснээр иргэн хүн засгийн газрын тиранаас, төрийн тиранаас хараат бус амьдрах болно. Милль либерализмын гол төлөөлөгчдийн нэг байсан учраас төлөөллийн удирдлагыг эрхэм болгож байсан. Ард түмэн төрийн удирдлага, үйл ажиллагаанд оролцож байх ёстай мөн төрт ёсны хөгжилд иргэд бас хариуцлагатай үүрэг хүлээх ёстай, ард түмэн өөрсдөө төрийнхөө хэлбэрийг сонгож баталдаг байх ёстай хэмээн сургаж байв. Мөн ард түмэн төрд бололцооны хэрээр дэмжлэг үзүүлдэг байх ёстай. Төрт ёсны төлөөллийн удирдлагад ард түмэн үүрэг хариуцлага үүрч байх нь эрхэм чухал. Төрийн удирдлага бол юуны өмнө бие хүний эрх чөлөө, сонирхол, өмч хөрөнгийг хамгаалдаг байх ёстай. “Сайн засгийн газар гэдэг бол ард иргэдээ сайн сайхнаар урагшлан дэвжихэд нь тусладаг байхыг хэлнэ”. Тийм засгийн газар ард иргэд нь эрх чөлөөтэй, өмч баялагтай, сайн сайхан амьдрах нөхцлийг хангаж өгнө.

Милль хүний нийгмийн хөгжлийн талаар сургасан. Юуг хөгжил гэх вэ? Юуг дэвшил гэх вэ? Хөгжил дэвшил бол тухайн ард түмэн, улс орон бат тогтвортой оршин тогтнож, цаашид хөгжих нөхцлийн үр дүн мөн. Тийм нөхцлийг бий болгогч гол хөдөлгөгч хүч нь хүн байна. Тиймээс хүний бүтээх, сайн сайхан амьдрах, эрх чөлөөтэй байх нөхцлийг төр хангаж байх ёстай. Энэ утгаар нь иргэн баян бол төр баян байх ёстай гэсэн санааг гаргаж тавьсан юм. Төрийн бүтэц зохион байгуулалт ямар байвал хөгжил дэвшилд үр ашигтай вэ? гэсэн санааг гаргаж тавиад засаглал хуваах зарчмыгдэмжиж байв. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглал бие биенээсээ хараат бус байх ёстай. Хууль тогтоох засаг бол нийгэмд шударга хуулийг гаргах хэрэгтэй. Хууль тогтоогчид, хууль ёс хоёрын аль аль гажиггүй байвал зохино. Гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэгч албан тушаалтууд албан үүргээ хувийн ашиг сонирхолд захируулж болохгүй. Парламентын үүрэг бол ард түмний санаа бодол, гомдол хүсэлтийг улс үндэстний эрх ашгийн үүднээс хяналт тавьж байх үүрэгтэй. Шүүх засаглал ард иргэдэд адил тэгшээр үйлчилж байх хэрэгтэй. Тэгж байж сая хууль шударгаар амьдралд хэрэгжинэ. Миллийн либерализм төрийн зохион байгуулалтын механизмыг ардчилсан, хууль эрх зүйн үндэс дээр өөрчлөн шинэчлэх үзэл санааг дэвшүүлснээрээ өнөө хэр ач холбогдолтой байгаа юм. Милль төрийн засаглалын үйл ажиллагааны чиглэл, хил хязгаар, үүрэг ролийн тухай дурдахаа засгийн газрын үүрэг бол байнга нэг хэвийн байх ёсгүй нөхцөл байдлаас хамааран байнга шинэчлэгдэж байх ёстийг сургаж байв. Гэхдээ үндэсний эрх ашиг гэдэг хэзээ ч өөрчлөгдөж болохгүй. “Нэгдсэн вант улсад мөнхийн найз гэж байхгүй, мөнхийн дайсан гэж байхгүй нэг

л зүйл мөнх тэр нь үндэсний эрх ашиг байх болно” хэмээн хожмын нэрт улс төрч У.Черчиль хэлсэн нь дээрхийн нотолгоо мөн.

Төр улсаа хөгжүүлэх арга зам бол үндэстний зорилго байх ёстой. Милль иргэний эрх, эрх чөлөөний тухай үзэл санааг ёс суртахууны хүнлэг зарчмуудад шигтгэж өгсөн. Бусдын эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хүндэтгэхийн хэрээр өөрийнхөө эрх чөлөөг илүүтэй мэдрэх болно. Төрийн удирдлагын үйл явцад амин хувия хичээсэн хүнд сурталт сонирхол бол ард түмний төрийг удирдах, төрийн үйл хэрэгт оролцоход хор уршиг тарина гэж тэрээр үзэж байжээ. Энэхүү либерал үзэл санааг дэвшүүлэгч сонгодогуудын эрхэмлэн дээдэлсэн үнэт зүйлс Монголын нийгмийн өнөөгийн цаг үед тулгарч буй олон асуудлыг нийтийн сайн сайхны үйл хэргийн үүднээс шийдвэрлэхэд ач холбогдоо хадгалсаар байгаа үзэл санаанууд мөн гэсэн үүднээс энэхүү өгүүллийг толилуулж байна.

**Түлхүүр үг:** францын хөрөнгөтний хувьсгал, либерал үзэл, хүний эрх, эрх чөлөө, либерализм

**Товч хураангуй:** Энэхүү өгүүлэлд либерализмыг үндэслэгчид гэгддэг И.Бентам, Дж.С.Милль нарын дэвшүүлж байсан нийгэм, төрийн шинэтгэлийн үзэл санаа арчиллын тулгуур үнэт зүйлсийн онолын үндэс болон хөгжиж ирсэн нь өнөөгийн Монгол дахь арчилсан шилжилтийн үеийн тулгамдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөө бүхий үр дагавар, үзүүлэх учир холбогдолоороо хэвээр байгааг өгүүлсэн болно.

#### ABSTRACT

Social and state reformation ideas of E.Bentham and J.S.Mill as being recognized as founding fathers of liberalism have been developed as a theoretical basis of democracy.

The article shows that above mentioned idea still has its essential influence for fulfilling stated aims of contemporary Mongolian democratic transition.